БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨМӨРБААТАР

БАТЛАВ.
"СҮР СҮЛД" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Э.МӨНХ-ЭРДЭНЭ

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 10 -р сарын 18 -ны өдөр Дугаар 2023-03/325 Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалтыг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нямхүү, Ус ашиглагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Улсын бүртгэлийн 9011818030, регистрийн 6570313 дугаартай "Сүр сүлд" ХХК-ийн захирал Э.Мөнх-Эрдэнэ нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн тооцож, 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр . Гэрээний нөхцөл:**

2.1. Ус ашиглах зориулалт:
Хайрга дайрга олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

2. 2 Ашиглах усны хэмжээ:
-Ундаргаар нь тооцож үзэхэд хоногт 18.5 $м^3$ ус авч ашиглах боломжтой. Үйлдвэрлэлийн газар нь хоногт 5.0 $м^3$ ус ашигладаг

1 ажилтан хоногт 20 л ус хэрэглэнэ 27 ажилтан 1 хоногт 0,54$м^3$ *172хоногт 92,88$м^3$,
1 $м^2$ талбай тоосжилт дарахад 2л ус зарцуулна гэж үзвэл 1500$м^2$ талбайн тоосжилт дарахад 3 $м^3$ ус ашиглах бөгөөд 50 удаа услахад 150,0 $м^3$,
1 ш мод услахад 15л ус хэрэглэнэ гэж үзвэл 1000 ширхэг навчит төрлийн мод 15 $м^3$* 25 удаа услахад 375 $м^3$ **Нийт 617,88$м^3$**

2.3. Усны чанар, найрлага:
Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS:0900:2018"-ын шаардлага хангаж байна.

2.4. Усны эх үүсвэрийн:
Байршил: Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Зүүн туруунд,
Солбицол: **47°55'46.01"N, 106°38'12.99"E**
Барилга байгууламж: Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар гаргасан 80 м гүн, өрмийн худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.
Тоног төхөөрөмж нэр марк:
Худагт Altas-455 маркын усны насосыг суурилуулсан.

2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил: Байхгүй хөрсөнд шингээдэг

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:
Жилд 256 кг.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: бохир ус зөөвөрлөх мэргэжлийн

байгууллагатай гэрээ байгуулж, бохир усыг зөөвөрлүүлж, бохирын төвлөрсөн шугамд нийлүүлэх.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөцийн бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Байхгүй.

2.9. Усны тоолуурын:

Загвар, нэр, дугаар: маркын усны насосыг суурилуулсан. 180600014 дугаартай гэрчилгээтэй, LXSG маркийн усны тоолуурыг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр суурилуулсан.

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2023 оны 03-р сарын 10-ны өдөр

Тоолуурын заалт: 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 2023/44 дугаартай ус ашиглуулах дүгнэлтэнд заасан тоолуурын заалт **00000**м$^3$.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг "Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай", Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 25-ний дотор тоолуурын заалтаар тооцож **/1м$^3$ ус 99,12 төг/** төлнө.

### Гурав. Талуудын эрх үүрэг.

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Усан орчин ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ж.Нямхүү

Байгаль орчин, ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн
С.Сүхцоож

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
27 дугаар хороо

Харилцах утас: 70173213

Ус ашиглагчийг төлөөлж:

"Сүр сүлд" ХХК-ийн
захирал Э.Мөнх-Эрдэнэ

SUR SULD LLC
СҮР СҮЛД ХХК
6570313 СБА7595
9020050397
УЛААНБААТАР ХОТ

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
33 дугаар хороо зүүн
турууны аманд
Харилцах утас: 95347341
99191593